



**ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2015/12

**Улаанбаатар хот
2016 он**

Агуулга	Хуудасны Дугаар
1. Мал аж ахуй	2
2. Ургац хураалт, өвс хадлан, гар тэжээл бэлтгэлт	5
3. Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	7
4. Экспорт, импортын гол нэрийн бараа	9
5. Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	11

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

МАЛ АЖ АХУЙ

Улсын хэмжээгээр 2015 оны эцэст 55979.8 мян.толгой мал, үүнээс 3295.3 мян.адуу, 3780.4 мян.үхэр, 368.0 мян.тэмээ, 24943.1 мян.хонь, 23592.9 мян.ямаа тоологдов.

Малын нийт тоо өмнөх оныхоос 3997.2 мянга буюу 7.7 хувиар, адуу 299.6 мянга буюу 10.0 хувь, үхэр 366.6 мянга буюу 10.7 хувь, тэмээ 18.7 мянга буюу 5.4 хувь, хонь 1728.3 мянга буюу 7.4 хувь, ямаа 1584.0 мянга буюу 7.2 хувиар өслөө.

Нийт мал сүрэгт хонь 44.6 хувь, ямаа 42.1 хувь, үхэр 6.8 хувь, адуу 5.9 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж, өмнөх оныхоос адуу, үхрийн эзлэх хувь 0.1-0.2 пунктээр өсч, хонь, ямааных 0.1-0.2 пунктээр буурч, тэмээнийх өмнөх оны түвшинд байна.

Малын тоо 2015 оны эцэст өмнөх оныхоос 14 аймаг, Улаанбаатар хотод 5 төрлөөр өсчээ. Өвөрхангай (399.5 мянга), Говь-Алтай (344.4 мянга), Дундговь (328.6 мянга), Баянхонгор (306.0 мянга), Хэнтий (282.4 мянга) аймагт малын тоо хамгийн их өсчээ.

Өвөрхангай (4511.0 мянга), Төв (4458.6 мянга), Архангай (4457.1 мянга), Хөвсгөл (4398.1 мянга), Баянхонгор (3771.9 мянга) аймаг 2015 онд хамгийн олон мал тоолуулж, малын тоогоор тэргүүлж байна.

Адуун сүргийн тоогоор Төв, Архангай, Өвөрхангай, Булган, Сүхбаатар аймаг; үхэр сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Булган, Хэнтий аймаг; тэмээн сүргийн тоогоор Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Дундговь аймаг; хонин сүргийн тоогоор Архангай, Төв, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий аймаг; ямаан сүргийн тоогоор Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд аймаг тэргүүлж байна.


Улсын хэмжээгээр 2015 оны эцэст 216.7 мянган малтай өрх байгаагийн 153.1 мян.өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчдын тоо 2015 оны эцэст 297.8 мянга болж, 16-34 насны малчид 36.0 хувь, 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 54.3 хувь, тэтгэврийн насны малчид 9.6 хувийг эзэлж байна.

Малтай нийт өрхийн тоо өмнөх оныхоос 1.6 хувиар, 500 хүртэлх малтай өрхийн тоо 0.1 хувиар буурч, харин 500-аас дээш малтай өрхийн тоо 12.9 хувиар өссөн байна.


Улсын хэмжээгээр малтай нэг өрхөд ногдох малын тоо 2015 онд дунджаар 257 болж, өмнөх оныхоос 15 толгой буюу 6.2 хувиар өслөө. Малтай нэг өрхөд 15 адуу, 17 үхэр, 2 тэмээ, 114 хонь, 108 ямаа ногдож байна. Өмнөх оныхоос малтай нэг өрхөд ногдох адуу, үхэр 1, хонь 6, ямаа 5-аар өсч, харин тэмээний тоо өөрчлөгдөөгүй байна.

**МАЛЫН ТОО, 2015 оны эцэст, бүс, аймаг, нийслэлээр
/мян.тол/**



Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2015 оны жилийн эцэст малын тоо **55957.6** мянган толгойд хүрч, өмнөх оныхоос **3975.0** мянган толгой буюу **7.6** хувиар өслөө.


Малын тоо, төрлөөр, мян.толгой




Нийт малын дүнд таван төрлийн малын эзлэх хувь

	Малын тоо, мян.толгой			Нийт малд 5 төрлийн малын эзлэх хувь		
	2013	2014	2015	2013	2014	2015
Б?гд	45 144.3	51 982.6	55 979.8	100.0	100.0	100.0
Адуу	2 619.4	2 995.8	3 295.3	5.8	5.8	5.9
?хэр	2 909.5	3 413.9	3 780.4	6.4	6.6	6.8
Тэмээ	321.5	349.3	368.0	0.7	0.7	0.7
Хонь	20 066.4	23 214.8	24 943.1	44.4	44.7	44.6
Ямаа	19 227.6	22 008.9	23 592.9	42.6	42.3	42.1


Бойжсон төл




100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох мал



Малтай өрхийн тоо, малын тооны бүлгээр



Малчин өрхийн тоо



УРГАЦ ХУРААЛТ, ӨВС ХАДЛАН, ГАР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛТ

Улсын хэмжээгээр 2015 онд нийт 519.5 мян.га талбайд тариалалт хийснээс 390.7 мян.га-д үр тариа, 12.8 мян.га-д төмс, 7.7 мян. га-д хүнсний ногоо, 23.8 мян.га-д тэжээлийн ургамал, 84.5 мян.га-д техникийн ургамал тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 78.9 мян.га буюу 17.9 хувиар нэмэгдсэн байна.

Үр тариа 216.3 мян.т, төмс 163.8 мян.т, хүнсний ногоо 72.3 мян.т-ыг 2015 онд хураан авч, 1028.7 мян.т хадлан, 39.9 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос үр тариа 302.5 мян.т буюу 58.3 хувь, хадлан 150.0 мян.т буюу 12.7 хувь, хүнсний ногоо 32.4 мян.т буюу 31.0 хувь, гар тэжээл 0.4 мян.т буюу 0.9 хувиар буурч, төмс 2.3 мян.т буюу 1.4 хувиар өссөн байна.

Нэг га-гаас 5.5 цн үр тариа, 127.5 цн төмс хураасан нь өмнөх оныхоос үр тарианых 11.0 цн буюу 66.7 хувиар буурч, төмснийх 5.2 цн буюу 4.3 хувиар өссөн байна. Үр тарианы га-гийн ургац Завхан, Төв, Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар, Дорноговь аймагт улсын дунджаас 0.9-3.9 центнерээр бага, харин бусад аймагт 0.1-12.7 центнерээр их байна.

Төмсний га-гийн ургац Увс, Ховд, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймагт улсын дунджаас 0.9-26.0 центнерээр их, харин Улаанбаатар хот болон бусад аймагт 13.7-90.3 центнерээр бага байна.


Хураасан үр тарианы 39.9 хувь нь Сэлэнгэ, 16.0 хувь нь Төв, 13.4 хувь нь Булган, 12.0 хувь нь Дорнод, 4.8 хувь нь Хөвсгөл аймагт; төмсний 45.0 хувь нь Төв, 23.2 хувь нь Сэлэнгэ, 6.1 хувь нь Ховд, 3.1 хувь нь Булган, 2.6 хувь нь Хэнтий аймагт ногдож байна.

Хураасан үр тарианы 57.6 хувь нь Төвийн, 22.6 хувь нь Хангайн, 17.5 хувь нь Зүүн, 2.3 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы хэмжээ өмнөх оныхоос Баруун бүсэд 3.3 мян.т буюу 39.4 хувь, Зүүн бүсэд 9.3 мян.т буюу 19.7 хувь, Хангайн бүсэд 40.5 мян.т буюу 45.4 хувь, Төвийн бүсэд 249.4 мян.т буюу 66.7 хувиар буурлаа.


Хураасан нийт хүнсний ногооны 36.8 хувь нь Сэлэнгэ, 12.0 хувь нь Ховд, 7.2 хувь нь Төв, 6.6 хувь нь Дархан-Уул аймагт, 5.2 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 144.9 мян.т буюу 14.1 хувь нь Сэлэнгэ, 143.7 мян.т буюу 14.0 хувь нь Хөвсгөл, 128.8 мян.т буюу 12.5 хувь нь Хэнтий, 86.6 мян.т буюу 8.4 хувь нь Булган, 71.6 мян.т буюу 7.0 хувь нь Архангай, 66.5 мян.т буюу 6.5 хувь нь Төв, 64.4 мян.т буюу 6.3 хувь нь Дорнод, 59.2 мян.т буюу 5.8 хувь нь Баян-Өлгий, 262.9 мян.т буюу 25.4 хувь нь Улаанбаатар хот болон бусад аймагт ногдож байна.

Хураасан үр тариа, мян.т
жил бүрийн эцэст




Хураасан төмс, хүнсний ногоо, мян.т
жил бүрийн эцэст



■ Төмс ■ Хүнсний ногоо

Бэлтгэсэн хадлан, мян.т
жил бүрийн эцэст



Хүнсний салбарын зарим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Үхрийн мах	т	7 373.7	5 496.4	3 074.2	55.9
Хонины мах	т	6 416.6	5 412.7	2 915.4	53.9
Адууны мах	т	2 354.6	2 237.5	3 731.6	166.8
Ямааны мах	т	3 614.1	3 636.7	1 958.6	53.9
Өлөн гэдэс	мян. ГОГЦОО	696.1	407.3	625.6	153.6
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	2 347.1	3 488.2	3 686.1	105.7
Шингэн сүү	мян.л	26 607.4	28 311.3	27 054.6	95.6
Тараг	мян.л	8 803.5	7 093.2	7 113.1	100.3
Цөцгий, цөцгийн тос	т	1 191.8	1 450.5	1 445.4	99.6
Аарц, бяслаг	т	140.7	106.9	146.6	137.1
Дээд гурил	т	45 789.1	45 217.6	39 752.9	87.9
Нэгдүгээр гурил	т	169 204.0	157 915.6	147 366.7	93.3
Хоёрдугаар гурил	т	31 519.1	25 181.2	22 052.4	87.6
Талх	т	25 047.4	30 159.4	28 620.4	94.9
Нарийн боов	т	18 747.3	18 822.5	17 969.2	95.5
Бялуу	т	860.8	1 017.6	1 228.5	120.7
Чихэр	т	44.6	56.4	42.7	75.7
Жигнэмэг	т	489.2	470.5	478.8	101.8
Гоймон	т	1 531.9	2 752.0	2 028.7	73.7
Пүнтүүз	т	49.6	33.2	34.4	103.6
Шарсан төмс	т	529.1	682.5	949.9	139.2

үргэлжлэл					
Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2013	2014	2015	$\frac{2015}{2014}$ %
Спирт	мян.л	1 925.4	9 126.0	8 668.6	95.0
Архи	мян.л	24 774.0	24 181.4	21 131.9	87.4
Дарс	мян.л	78.3	76.7	75.0	97.8
Шар айраг	мян.л	63 775.3	67 740.7	74 857.2	110.5
Цэвэр ус	мян.л	47 360.4	52 119.0	60 550.2	116.2
Амтат ус, ундаа	мян.л	78 781.3	92 537.0	112 571.4	121.7
Жүүс	мян.л	84 426.6	80 178.3	70 329.1	87.7
Тамхи	мян.блок	6 299.8	6 432.4	5 086.3	79.1

Экспортын зарим нэрийн бараа

Гол нэр төрлийн бараа	Хэм. нэгж	2014		2015*		$\frac{2015^*}{2014}$ %	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Адууны мах	т	1 822.2	4 971.5	3 856.9	7 318.5	211.7	147.2
Малын дайвар бүтээгдэхүүн	т	202.8	238.9	42.7	88.3	21.1	37.0
Богийн өлөн гэдэс	т	339.6	7 986.9	424.9	8 851.5	125.1	110.8
Адууны дэл, сүүл	т	606.0	860.6	974.4	2 868.7	160.8	3.3**
Үхэр, адууны боловсруулсан шир	сая дм ²	58.4	7 981.9	69.5	8 284.6	119.0	103.8
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	240.0	2 870.8	117.9	1 799.4	49.1	62.7
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая дм ²	110.2	10 880.5	147.7	12 274.3	134.0	112.8
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая дм ²	128.8	13 737.6	122.3	10 256.8	95.0	74.7
Хонины самнаагүй ноос	т	7 351.3	9 577.8	11 450.3	13 945.5	155.8	145.6
Бохир ноолуур	т	4 035.4	223 815.4	4 988.2	197 181.0	123.6	88.1
Самнасан ноолуур	т	636.6	61 931.8	558.9	40 711.2	87.8	65.7

Тайлбар: ** -дахин их

Импортын гол нэрийн бараа

Гол нэр төрлийн бараа	Хэм- жих нэгж	2014		2015*		$\frac{2015^*}{2014}$ %	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Өндөг	мян.ш	87 275.1	7 891.0	66 427.4	4 665.5	76.1	59.1
Тахиа, шувууны							
мах ба дайвар	т	8 870.8	15 537.4	5 826.3	10 831.5	65.7	69.7
бүтээгдэхүүн							
Гахайн мах, өөх	т	4 801.6	8 389.4	4 985.1	6 602.3	103.8	78.7
Төмс	т	5 409.5	1 008.3	17 058.9	3 468.2	3.2**	3.4**
Сонгино, сармис	т	19 074.7	3 584.9	8 623.3	2 227.3	45.2	62.1
Алим, лийр	т	13 303.6	6 358.0	16 521.6	6 766.1	124.2	106.4
Ногоон цай	т	1 553.4	1 595.5	1 844.1	1 718.9	118.7	107.7
Цагаан будаа	т	29 596.1	14 887.0	24 508.1	15 846.1	82.8	106.4
Улаан буудай	т	34 228.1	10 830.7	21 070.9	4 457.7	61.6	41.2
Гурил	т	17 518.2	6 710.7	20 509.5	6 012.8	117.1	89.6
Ургамлын тос	т	8 787.8	10 008.4	9 321.3	9 777.7	106.1	97.7
Элсэн чихэр	т	44 583.4	24 458.7	39 274.3	18 412.8	88.1	75.3
Хатуу чихэр	т	5 502.2	11 373.2	5 544.2	9 090.0	100.8	79.9
Амтлаг гурилан зүйлс	т	14 422.2	31 413.3	13 678.9	26 458.6	94.8	84.2
Лаазалсан жимс, самар	т	71.7	104.9	11.1	49.5	15.5	47.2
Өтгөрүүлсэн, хуурай сүү, цөцгий	т	5 784.2	21 577.1	4 652.9	9 552.5	80.4	44.3
Зайрмаг	т	2 733.3	5 441.2	2 508.8	5 194.0	91.8	95.5

Гол нэр төрлийн бараа	Хэм-жих нэгж	2014		2015*		$\frac{2015^*}{2014}$ %	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Согтууруулах бус ундаа	мян.л	20 986.2	18 989.5	15 908.7	13 965.9	75.8	73.5
Согтууруулах ундаа	мян.л	24 434.9	26 770.4	18 143.0	17 994.2	74.3	67.2
Үүнээс: Шар айраг	мян.л	21 676.3	11 737.2	15 860.5	7 193.5	73.2	61.3
Янжуур	сая.ш	2 042.9	51 115.1	2 026.2	52 239.4	99.2	102.2
Дүнсэн тамхи	т	245.7	1 086.1	302.4	1 702.9	123.1	156.8

Тайлбар: ** -дахин их

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2015 оны 12 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Хөвсгөл, Баянхонгор, Увс, Дундговь, Завхан, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 20.0-30.0 мян.төг; Говь-Алтай, Орхон, Төв, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 40.0-43.0 мян.төг; адууны ширнийх Увс, Орхон, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дундговь аймагт хамгийн бага буюу 28.0-37.0 мян.төг; Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Хэнтий, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 50.0-60.0 мян.төг; ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Говь-Алтай, Баянхонгор аймагт хамгийн бага буюу 30.0 мян.төг; Завхан, Архангай, Орхон аймагт хамгийн их буюу 40.0-50.0 мян.төг байна.